

НАСС-ИЙН ОЮУТНЫ ЦАХИМ СУРГАЛТЫН ТАЛААРХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

П.Билэгсайхан¹, Г.Мөнхжаргал¹, О.Болормаа², Б.Батбаяр³

^{1,3} АШУҮИС, НАСС

² АШУҮИС, ТӨСБЗГ

bilegsaikhan.p@mnum.edu.mn

Хүлээн авсан огноо: 2021.10.21

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор М.Оюун

Үндэслэл

Сэтгэл ханамж нь бизнесийн салбарт түгээмэл хэрэглэгддэг хэллэг бөгөөд бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хэрэглэгчийн хүлээлтэд хэрхэн нийцэж байна вэ гэдгийг тодорхойлдог өргөн хүрээний ойлголт юм. Энэхүү ойлголт нь боловсролын байгууллагад ч ач холбогдолтой юм. Боловсролын байгууллагын хэрэглэгчид болох оюутнуудын сэтгэл ханамжийг тодорхойлсноор оюутны оролцоог нэмэгдүүлэх багш, удирдлагын үйл ажиллагааг сайжруулахад түлхэц болох юм. Оюутны сэтгэл ханамж нь оюутнуудын боловсролын туршлагыг үнэлсэн үр дүнгийн богино хугацааны хандлага юм.¹ Оюутнуудын сэтгэл ханамж бол олон талт үйл явц бөгөөд үүнд янз бүрийн хүчин зүйл нөлөөлдөг. Нэгэн судалгааны ажилд мэдээлснээр сурлагын дундаж оноо (GPA) нь оюутны сэтгэл ханамжид хамгийн их нөлөөлдөг хүчин зүйл гэсэн байна.² Гэхдээ нөгөө талаас Вилкинс ба Балакришнан нарын тодорхойлсноор оюутнуудын сэтгэл ханамжийг тодорхойлох гол хүчин зүйл нь багшийн ур чадвар, чанартай материаллаг бааз, технологийг үр дүнтэй ашиглахыг тодорхойлжээ.³ Түүнчлэн их дээд сургуулийн оюутнуудын сэтгэл ханамжид анги танхим, багш оюутны харилцаа, бусад оюутнуудтай харилцах харилцаа, хичээлийн агуулга, сургалтын тоног төхөөрөмж, номын сан, сургалтын хэрэглэгдэхүүн ихээхэн нөлөөлдөг байна.^{4,5,6}

Манай улсад COVID-19 цар тахалтай холбоотой хатуу хөл хорио тогтоосны улмаас 2020-2021 оны хичээлийн жилд хичээл сургалт бүхэлдээ цахим байдалд шилжсэн. COVID-19 цар тахалтай холбоотой хөл хорионы дэглэм тогтоосноор анагаахын сургуулиуд эмнэлзүйн сургалтаа зогсоож, цахим сургалтад шилжсэн. Энэхүү судалгааны зорилго нь хөл хорионы дэглэмийн үед нүүр ам судлалын чиглэлээр суралцагчдын цахим сургалтын үр дүнг оюутнуудын өнцгөөс судалж сэтгэл ханамжийг тодорхойлох явдал юм.

Зорилго, зорилт

АШУҮИС, НАСС-н цахим сургалтад оюутны сэтгэл ханамжийг судлах зорилгын хүрээнд 2020-2021 оны хичээлийн жилийн, НАС, НАТ, НАЭА –н 1-6 дамжааны оюутнуудаас цахим хичээлийн талаарх санал асуулга авах

Судалгааны материал, арга зүй


АШУҮИС, НАСС-ийн Нүүр ам судлал, нүүр амны технологи, нүүр амны эрүүл ахуйн ангийн 2020-2021 оны хичээлийн жилд цахимаар суралцаж буй 1-6 дамжааны оюутнуудаас “Google form” ашиглан дараах асуултаар хөл хорионы үеийн цахим хичээлийн талаарх сэтгэл ханамжийн байдлын тухай асуумж авсан. Судалгаанд дараах асуумжаар сэтгэл ханамжийг тодорхойлсон.

1. Багш цахим хичээлд хэрхэн бэлдсэн эсэх
2. Багш хичээлийг сонирхолтой бөгөөд ойлгомжтой заадаг эсэх
3. Багшийн хичээлээр олгож буй мэдлэг, чадвар суралцах хүслийг нэмэгдүүлдэг эсэх
4. Цахим хичээлд үнэлгээг хэрхэн тооцох нь ойлгомжтой байдаг эсэх
5. Цахим хичээлээр сурахыг хүссэн зүйлээ сурч, мэддэг эсэх

Статистик боловсруулалтыг SPSS 23 программ ашиглан боловсруулав.


Үр дүн

Судалгаанд нийт АШУҮИС, НАСС-ийн НАС, НАТ, НАЭА ангийн 1-6 дамжааны нийт 347 оюутан (эрэгтэй 43, эмэгтэй 304) хамрагдсан. Үүнээс НАС 305, НАТ 35, НАЭА 7 оюутан тус тус судалгаанд оролцсон. Судалгаанд оролцогсод тухайн үед өөрийн ангид орж байгаа цахим хичээлийг үнэлсэн. Судалгаанд оролцогсдыг дамжаагаар авч үзвэл 1-р дамжааны 8,9% (n=31), 2-р дамжааны 2,3% (n=8), 3-р дамжааны 24,2% (n=84), 4-р дамжааны 23,6% (n=82), 5-р дамжааны 20,7% (n=72), 6-р дамжааны 20,1% (n=70) оюутан оролцсон байна. (Зураг 1)




Зураг 1. АШУУИС, НАСС-н судалгаанд оролцсон оюутнуудыг дамжаагаар харуулав

1. Багш цахим хичээлд хэрхэн бэлдсэн талаарх асуулгад НАГЗТ 87,5%, ХНАСУСТ 80,6%, НАЭТ 70%, НАСЗТ 65,5%, НАТ 60,5%, НАМЗТ 58,2%, ШТЭСЭТ 55,6%, Ерөнхий эрдмийн хичээл 49% нь сайн бэлдсэн байдаг гэсэн байна.
2. Багш хичээлийг сонирхолтой бөгөөд ойлгомжтой заадаг эсэх асуулгад ХНАСУСТ 67,2%, НАГЗТ 62%, НАЭ 55%, НАСЗТ 46,6%, Ерөнхий эрдмийн хичээл 43,1%, НАТ 39,5%, ШТЭСЭТ 38,9%, НАМЗТ 34% нь сонирхолтой ойлгомжтой байдаг гэж хариулсан байна.
3. Багшийн хичээлээр олгож буй мэдлэг, чадвар миний суралцах хүслийг нэмэгдүүлдэг эсэх асуулгад ШТЭСЭТ 100%, НАЭТ 100%, ХНАСУСТ 97,9%, НАСЗТ 96,7%, НАМЗТ 92,6%, НАГЗТ 90%, Ерөнхий эрдмийн хичээл 86,3%, НАТ 73,3% нь маш сайн гэсэн үнэлгээ өгсөн байна.
4. Цахим хичээлийн үнэлгээг хэрхэн тооцох нь ойлгомжтой байдаг эсэх талаарх асуулгад НАГЗТ 68,8%, ХНАСУСТ 64,2%, НАСЗТ 56,9%, НАМЗТ 49,4%, НАЭТ 45%, НАТ 39,5%, Ерөнхий эрдмийн хичээл 35,3%, ШТЭСЭТ 22% нь үнэлгээ ойлгомжтой байдаг гэж хариулсан байна.
5. “Цахим хичээлээр сурахыг хүссэн зүйлээ сурч, мэддэг” талаар цахим сургалтад өгөх сэтгэл ханамжийн асуулгад нийт судалгаанд хамрагдсан 347 оюутны 13,6% бүрэн сурч мэддэг, 26,4% ихэнх хичээлийг сурч мэддэг, 39,6% дунд зэрэг, 14,6% санал нийлэхгүй, 5,8% нь огт санал нийлэхгүй байна хэмээн хариулсан байна. Үүнийг дамжаа тус бүрээр авч үзвэл 1-р дамжааны 29,1% сэтгэл ханамжтай, 48,4% дунд зэрэг, 22,5% сэтгэл ханамжгүй, 2-р дамжаа 37,5% сэтгэл ханамжтай, 37,5% дунд зэрэг, 25% сэтгэл ханамжгүй, 3-р дамжаа 45,3% сэтгэл ханамжтай, 23,2% дунд зэрэг, 35% сэтгэл ханамжгүй, 4-р дамжаа 46,4% сэтгэл ханамжтай, 36,6% дунд зэрэг, 17% сэтгэл ханамжгүй, 5-р дамжаа 32,4% сэтгэл ханамжтай, 38,9 дунд зэрэг, 28,8% сэтгэл ханамжгүй, 6-р дамжаа 38,6% сэтгэл ханамжтай, 42,9% дунд зэрэг, 18,6% сэтгэл ханамжгүй гэж хариулсан байна.



Зураг 2. Цахим хичээлээр сурахыг хүссэн зүйлээ сурч, мэддэг эсэхийг дамжаа тус бүрээр үзүүлэв

“Цахим хичээлээр сурахыг хүссэн зүйлээ сурч, мэддэг” талаар цахим сургалтад өгөх сэтгэл ханамжийн асуулгын үр дүнг тэнхим тус бүрээр харуулахад НАЭ 50% сэтгэл ханамжтай, 40% дунд зэрэг, 10% сэтгэл ханамжгүй, ерөнхий эрдмийн хичээл 43,2% сэтгэл ханамжтай, 43,1% дунд зэрэг, 13,8% сэтгэл ханамжгүй, НАСЗТ 43,1% сэтгэл ханамжтай, 32,8% дунд зэрэг, 14,1% сэтгэл ханамжгүй, ХНАСУСТ 40,3% сэтгэл ханамжтай, 38,8% дунд зэрэг, 20,9% сэтгэл ханамжгүй, ШТЭСЭТ 38,9% сэтгэл ханамжтай, 33,3% дунд зэрэг, 27,8% сэтгэл ханамжгүй, НАТ 36,9% сэтгэл ханамжтай, 42,1% дунд зэрэг, 21% сэтгэл ханамжгүй, НАМЗТ 36,8% сэтгэл ханамжтай, 40,5% дунд зэрэг, 22,8% сэтгэл ханамжгүй, НАГЗТ 31,3% сэтгэл ханамжтай, 56,3% дунд зэрэг, 12,6% сэтгэл ханамжгүй гэсэн байна. (Зураг 3)



Зураг 3. Цахим хичээлээр сурахыг хүссэн зүйлээ сурч, мэдэж байгаа талаарх сэтгэл ханамжийн байдлыг тэнхим тус бүрээр харьцуулан харуулав.

Дээрх 5 асуултын дунджаас үзэхэд судалгаанд хамрагдсан нийт оюутны цахим сургалтын талаарх сэтгэл ханамж 58.72%-д нь сайн байсан байна.

Хэлцэмж

2020-2021 оны хичээлийн жилд 2020 оны 11 сарын 17-оос сургалтын үйл ажиллагаа цахимд шилжсэнтэй холбоотойгоор оюутны цахим сургалтад сэтгэл ханамжийн судалгаа хийхэд судалгаанд хамрагдсан НАСС-н оюутны 58.72% нь сэтгэл ханамж сайн гэсэн үр дүн гарсан байна. БШУЯ-наас гаргасан тайлан мэдээнд их дээд сургуулиудийн цахим хичээлийн талаарх оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаанд 82.5% нь сэтгэл ханамжтай гэсэн байна. Энэхүү сэтгэл ханамжийн судалгаатай харьцуулж үзэхэд НАСС-н цахим хичээлийн сэтгэл ханамж харьцангуй бага байгаа нь хэд хэдэн хүчин зүйлстэй хамааралтай

байж болно. Үүнд: Хатуу хөл хорионы үед номын сангууд хаасан, цахим номын сангийн хүртээмж муу байсан байх талтай. Нөгөөтээгүүр дадлагын ихэнх хичээл эмнэл зүйн хичээл байдаг, эмнэлзүйд шүд ломбодох, шүд авах, шүд засах, амнаас хэв авах... гэх мэт гардан үйлдлийг хийхэд орчин, тусгай тоног төхөөрөмж, багаж материал шаардлагатай байдаг ба эдгээр үйлдлийг зөвхөн фантом болон хүн дээр хийх боломжтой байдагтай шууд холбоотой байх талтай. Цахим хичээлээр гардан үйлдлийг хийж гүйцэтгэх боломжгүй тул “Цахим хичээлээр сурахыг хүссэн зүйлээ сурч, мэддэг” эсэх сэтгэл ханамжийн асуултад хамгийн бага үнэлгээ өгсөн байх талтай юм. Харин “Багшийн хичээлээр олгож буй мэдлэг, чадвар миний суралцах хүслийг нэмэгдүүлдэг” эсэх асуулгад хамгийн их сэтгэл ханамжтай байсан байна. Сусан Хаттер нарын судалгаанд Иорданы их сургуулийн, шүдний сургуулийн оюутнууд “Ковид-19” цар тахлын хөл хорионы үед цахим сургалтаар эмнэлзүйн ур чадварын талаар сэтгэл ханамжийн судалгаанд эмнэлзүйн ур чадварт бүрэн суралцаагүй гэж 87% хариулсан байна.⁶ Нүүр амны их эмч, нүүр амны техникч бэлтгэх сургалт нь эмнэлзүйн дадлага, гардан үйлдэл, практик дээр тулгуурлаж явагддаг тул виртуал цахим сургалт үүнийг бүрэн орлож чадахгүй юм.

Дүгнэлт

Нүүр ам судлалын чиглэлээр суралцдаг оюутнууд цахим сургалтын зарим зүйлд сэтгэл ханамжтай байгаа боловч эмнэлзүйн сургалтыг цахим хэлбэрээр орох нь учир дутагдалтай гэж үзсэн байна.

STUDENT SATISFACTION WITH ONLINE LEARNING IN SCHOOL OF DENTISTRY

P.Bilegsaikhan¹, G.Munkhjargal, B.Bayarchimeg, B.Batbayar²
MNUMS, School of Dentistry^{1, 2}
bilegsaikhan.p@mnums.edu.mn

Introduction:

Student satisfaction in universities is greatly influenced by quality of class room, quality of feedback, lecturer-student relationship, interaction with fellow students, course content, available learning equipment, library facilities and learning materials^{3,4,5} *The quarantine with the COVID-19 pandemic forced medical schools to suspend their clinical training and to shift to online learning. The aim of this study is to explore the efficacy of online learning from students' perspectives.*

Methods:

The questionnaire distributed to dental students comprised of online learning experience. The study was conducted using “Google form”.

Results and Conclusion:

Dentistry students appreciated the online learning, whereas they did not consider it a substitute for clinical practice.

Key words: online learning, satisfaction

Ном зүйн жагсаалт

1. Elliott, K. Healy, M. Key factors influencing student satisfaction related to recruitment and retention. *Journal of Marketing for Higher Education*. 2001; 1-11.
2. Marzo-Navarro, M., Iglesias, M. & Torres, M. A new management element for universities: satisfaction with the offered courses. *International Journal of Educational Management*, 2005. 19(6); 505-526.
3. Garci a-Aracil, A. European graduates' level of satisfaction with higher education. *Journal of Higher Education*, 2009. 57(1); 1-21.
4. Kuh, G. & Hu, S. The effects of student-faculty interaction in the 1990s. *Review of Higher Education*, 2001. 24(3); 309-332.
5. Sojkin, B., Bartkowiak, P. & Skuza, A. Determinants of higher education choices and student satisfaction: the case of Poland. *Higher Education*, 2012.63 (5); 565-
6. [Susan Hattar](#), [Abeer AlHadidi](#), [Faleh A. Sawair](#), et all. [BMC Medical Education](#) Impact of COVID-19 pandemic on dental education: online experience and practice expectations among dental students at the University of Jordan 2021.21 (151);